



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн
ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан*

Засгийн газрын тусгай сангийн үйл
ажиллагааны үр дүн



САНГУУДЫН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Улаанбаатар хот
2014 он

Тайланг бэлтгэсэн:

**ҮАГ-ын Нийцлийн
аудитын газар**

Газрын дарга

Б.Алтанзул

Аудитын менежер

З.Ариунзаяа

Аудитор

Ц.Эрдэнэчулуун

Шинжээч

Л.Нямтөмөр

Ш.Наранбаатар

Б.Билэгт

2014 оны 6 дугаар сар

***Уг тайланг ҮАГ-ын
вэб сайт-аас үзнэ үү:
www.audit.mn***

*Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
261729 дугаарын утас,
260949 дугаарын
факсаар харилцана уу.*

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160
Монгол улс

Агуулга	1
Товчилсон үгсийн жагсаалт	2
Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Ерөнхий мэдээлэл	4
Бүлэг 1.Сангуудын орлогын бүрдүүлэлтийн талаар	7
Сангуудын орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй, эх үүсвэрийг бүрэн төвлөрүүлж чадахгүй байна	7
Бүлэг 2.Сангуудын зарцуулалтын талаар	10
Нийгмийн даатгалын зарим сангийн хөрөнгийн зарлага батлагдсан төлөвлөгөөнөөс давж гарсан байна	
ЗГ-ын тусгай сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байна	10
	14
Бүлэг 3. Хяналт шалгалтын талаар	
Сангийн хөрөнгийг зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт үр дүн хангалтгүй байна	14
	17
Дүгнэлт	18
Зөвлөмж	
	18
Хавсралт 1	

ТӨВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АХГГГАХМАТ	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
АСТС	Архидан согтуурахтай тэмцэх сан
БГД	Баянгол дүүрэг
БНСУ	Бүгд найрамдах Солонгос Улс
БНҮҮС	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЗГ	Засгийн газар
МШХХТГ	Мэдээлэл шуудан, харилцаа холбоо, технологийн газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДТХ	Нийгмийн даатгалын тухай хууль
НДС	Нийгмийн даатгалын сан
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам (хуучнаар)
ОАТ	Онцгой албан татвар
ӨСНАТ	Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮОМШӨДС	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТБОНӨХБАҮ ХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
ЧД	Чингэлтэй дүүрэг
ХЯ	Хөдөлмөрийн яам
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЗЯ	Хууль зүйн яам
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хүний хөгжил сан
ХҮГ	Халамж, үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭДТХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМДС	Эрүүл мэндийг дэмжих сан
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 3 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторт 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт

Монгол Улсын Засгийн газрын зарим тусгай сангийн үйл ажиллагаа, үр дүнд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Сангуудын мөнгөн хөрөнгийн бүрдүүлэлтийг хууль тогтоомжтой уялдуулан бодитой төлөвлөсөн эсэх;
2. Сангуудын хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж байгаа эсэх;
3. Сангуудын хөрөнгийг зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх.

3. Хамарсан хүрээ

Аудитаар ЭМЯ, СЯ, ХАХНХЯ, ХЯ, ХЗЯ, ГХЯ болон холбогдох бусад байгууллагуудын эрхлэн хариуцаж буй Монгол Улсын Засгийн газрын дараах тусгай сангуудын 2013 оны үйл ажиллагааг хамруулав. Үүнд:

- Нийгмийн даатгалын сан
- Хүний хөгжил сан
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- Эрүүл мэндийг дэмжих сан
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
- Архидан согтуурахтай тэмцэх сан

4. Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан зарим тусгай сангийн хариуцсан ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Ерөнхий мэдээлэл

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 3 дугаар тогтоолын дагуу Үндэсний аудитын газар ЗГ-ын нэр бүхий 6 тусгай сангийн 2013 оны хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аудит хийлээ.

Аудитаар ЭМЯ, ХЗЯ, ХЯ, НДЕГ, аймаг, нийслэлийн 22, Улаанбаатар хотын 5 дүүргийн НДХ-ийг хамруулан 378.9 сая төгрөгийн зөрчилд 87 акт, 6.553,7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 48 албан шаардлага өглөө. *(Төлбөр зөрчлийг хавсралт № 1-ээр харуулав.)*

Нийгмийн даатгалын сан

Монгол Улсын Нийгмийн даатгалын сан нь тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний, ажилгүйдлийн, эрүүл мэндийн даатгалын сангуудаас бүрдэж байна.

Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу НДҮЗ нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөө, зарлагын гүйцэтгэлийг хэлэлцэн баталж, хяналт тавих үүргийг хүлээж байна.

Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллага 2013 онд нийгмийн даатгалын санд нийт дүнгээр 1,018.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, уг сангаас 1,058.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлжээ.

№	Сангийн нэр	Орлого	Зарлага
1	Тэтгэврийн даатгалын сан	635.0	826.4
2	Тэтгэмжийн даатгалын сан	67.3	58.6
3	ҮОМШӨ даатгалын сан	86.7	31.4
4	Ажилгүйдлийн даатгалын сан	25.8	16.1
5	Эрүүл мэндийн даатгалын сан	204.0	125.5
	Бүгд	1,018.8	1,058.0

Хүний хөгжил сан

УИХ-ын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Стратегийн томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчин, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлэх” гэж заасан бөгөөд УИХ-аас ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор Хүний хөгжил сангийн тухай хуулийг 2009 онд баталсан байна.

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Сангийн хөрөнгийн ерөнхий удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Сангийн хөрөнгийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, хэрэгжүүлнэ” гэж тус тус заажээ.

Хүний хөгжил санд 2010-2013 онд нийт 1,306.9 тэрбум төгрөгийн хөрөнгө төвлөрүүлж, 2,229.9 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, зөрүү 923.0 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгийн өөрчлөлтөөр 139.9 тэрбум, урьдчилгаа төлбөрөөр 522.4 тэрбум, ЗГ-ын бондоор 260.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлжээ.

Тус сан 2013 оны хувьд АМНАТ-өөс 195.8 тэрбум, ӨСНАТ-өөс 129.1 тэрбум, хувьцааны ногдол ашгаас 68.3 тэрбум, хүүгийн орлогоос 0.2 тэрбум нийт 393.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төр хариуцах ЭМД-ын шимтгэлд 12.1 тэрбум, 0-18 насны хүүхдэд олгох мөнгөнд 228.9 тэрбум, өмнөх онд олгосон бэлэн мөнгөө аваагүй иргэдэд 28.6 тэрбум, ЗГ-ын зээл, бондын хүүд 8.5 тэрбум, нийт 278.2 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Эрүүл мэндийг дэмжих сан

Эрүүл мэндийг дэмжих сангийн орлогыг архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгө болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр заажээ.

ЭМДС-ийн хөрөнгийг Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам”-д архи, тамхины эсрэг, нийтийн биеийн тамирыг дэмжих, эмнэлгийн үйл ажиллагаа, эмч мэргэжилтнүүдийн чадварыг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулахаар заажээ.

Сангийн удирдлага нь орон тооны бус 11 хүний бүрэлдэхүүнтэй Сангийн зөвлөл бөгөөд сангийн үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын ЭМДС-ийн Ажлын алба гүйцэтгэдэг байна.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар ЭМДС-ийн 2013 оны үйл ажиллагаанд зориулж 3,989.4 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 127 төсөл арга хэмжээг 2,469.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг байгуулна.”, мөн зүйлийн 21.2-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан байна.

ХЭДС нь ХЭДТХ-ийн 22 дугаар зүйлд заасан 8 эх үүсвэрээс орлогыг бүрдүүлж, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан 12 үйл ажиллагаанд хөрөнгийг зарцуулж, ХЭҮЗ нь сангийн хөрөнгийн жил бүрийн зарцуулалтын хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаж байна.

2013 онд сангийн орлогыг 79.5 тэрбум төгрөгөөр төвлөрүүлж, нийт төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд 42.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон Засгийн газрын 2009 оны 151-р тогтоолоор баталсан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, зарцуулах журам”-д заасны дагуу харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгөөр төрийн бодлогын хүрээнд зайлшгүй шаардлагатай мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх үүргийг хэрэгжүүлж байна.

БНҮҮС-ийн орлого нь мэдээлэл, шуудан харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс тухайн этгээдийн албан татвар ногдох орлогын 2 хувьтай тэнцэх хөрөнгө, шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүсэд үйлчилгээ үзүүлэгч шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх хөрөнгийн эх үүсвэрээс тус тус бүрдэж байна.

“Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам”-д заасны дагуу сангийн хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хянах үйл ажиллагааг МШХХТГ хариуцаж ажиллаж байна.

2013 онд тус сан нь 2.9 тэрбум төгрөг төвлөрүүлж, 2.7 тэрбум төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Архидан согтуурахтай тэмцэх сан

Архидан согтуурахтай тэмцэх сан нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрэм”-д заасны дагуу Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд сангийн зөвлөлийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

2013 оны Төсвийн тухай хуулиар хууль зүйн сайдын төсвийн багцад архидан согтуурахтай тэмцэх үйл ажиллагаанд зарцуулахаар 674.5 сая төгрөгийг баталж, улсын төсвөөс санхүүжүүлжээ.

Бүлэг 1 Сангуудын орлогын бүрдүүлэлтийн талаар

Сангуудын орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй, эх үүсвэрийг бүрэн төвлөрүүлж чадахгүй байна

1.1 Аудитад хамрагдсан 6 сангийн 4 нь 2013 онд орлогын төлөвлөгөөгөөр, 2 нь орлого төлөвлөөгүй, зардлын санхүүжилтийг улсын төсөвт шууд тусгасан байна.

1.2 Нэр бүхий Засгийн газрын тусгай сангуудын 2013 оны орлогын бүрдүүлэлтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Сангийн нэр	Орлого		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Нийгмийн даатгалын сан	971.5	1,018.8	47.3
2	Хүний хөгжил сан	397.5	393.5	-4.0
3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	87.4	79.0	-8.4
4	Бүх нийтийн үүргийн сан	3.5	2.9	-0.6

(тэрбум.төг)

Нийгмийн даатгалын сан

1.3 Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг 2013 онд нийт дүнгээр нь 47.3 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч шимтгэл төлөгчөөр авч үзвэл аж ахуйн нэгж, төсөвт албан газар, ажиллагсад, нөхөн олговор авагчдын төлөх шимтгэлийн орлого 25.5 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар дутуу биелсэн, харин сайн дурын даатгуулагч, гадаадад ажиллаж буй иргэдийн төлсөн шимтгэл 38.5 тэрбум, НДС-ийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд хадгалуулсны хүүгийн орлого 34.2 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Сангуудын эх үүсвэрийг шимтгэл төлөгчийн ангиллыг хүснэгтээр үзүүлбэл:

Шимтгэл төлөгчийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Бодит биелэлт	Биелсэн	Тасарсан	Хувь
Аж ахуйн нэгжээс төлсөн шимтгэл	408,951.3	398,561.9	-10,389.4		10,389.4	2.54
Төсөвт газраас төлсөн шимтгэл	133,272.8	129,541.9	-3,730.9		3,730.9	2.8
Ажиллагсдаас төлсөн шимтгэл	375,653.6	364,371.1	-11,282.5		11,282.5	3.0
Нөхөн олговор авагчдын шимтгэл	6.2	0.9	-5.3		5.3	15.19
Сайн дурын даатгуулагчаас төлсөн НДС	22,093.6	60,231.2	38,137.5	38,137.5		272.6
Гадаад улсад ажиллаж буй иргэдийн төлсөн шимтгэл	1,400.0	1,841.7	441.7	441.7		31.55
ҮОМШӨДС-аас төлсөн шимтгэл	919.9	781.4	-138.5		138.5	15.1
Төр бүрэн хариуцах даатгуулагчийн шимтгэл	12,151.5	12,151.5				
Бусад орлого(хүү)	17,088.5	51,341.5	34,252.9	34,252.9		200.4
Нийт орлого	971,537.5	1,018,823.3	47,285.7	72,832.3	25,546.5	4.8

/сая.төг/

1.4 Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг давуулж биелүүлэхэд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг авч үзвэл:

- Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хууль батлагдсаны дараагаар “Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хууль батлагдаж хэрэгжсэнээр 497.6 мянган иргэн сайн дурын даатгалд хамрагдаж ажилласан жилээ нөхөн тооцуулан, тэтгэврийн даатгалын санд 29.0 тэрбум төгрөгийн шимтгэл нэмж орсон;
- Эдгээр иргэдээс 46.9 мянган иргэн сайн дурын даатгалд үргэлжлүүлэн хамрагдаж, шимтгэлийн орлого 8.7 тэрбум, БНСУ-д гэрээгээр ажиллаж байгаа

иргэдийн төлсөн шимтгэлийн валютын ханшны өөрчлөлтөөр 441.7 сая төгрөгийн орлого тус тус нэмэгдсэн;

- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, Монголбанк, НДҮЗ-ийн шийдвэрээр арилжааны 18 банктай гэрээ байгуулж, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 245.0 тэрбум төгрөгийг хадгаламжид байршуулсны хүүнд 34.2 тэрбум төгрөгийн орлого нэмж олсон байна.

1.5 Аж ахуйн нэгж байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээ 2012 оны хагас жилийн тайлант хугацаанд төлөвлөснөөс 57.8 хувь буюу 56.1 тэрбум төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй гарч, төсвийн тодотголоор төлөвлөгөөг 28.5 хувиар өсгөж баталсан нь аж ахуйн нэгж болон ажиллагсдаас төлөх шимтгэл төлөвлөсөн хэмжээнээс 25.5 тэрбум төгрөгөөр тасрахад хүрчээ.

Хүний хөгжил сан

1.5 Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулиар тус сангийн орлогыг 397.5 тэрбум, зарлагыг 282.8 тэрбум төгрөгөөр баталсан байна.

1.6 2013 онд уул уурхайн салбарын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого тасарсанаас сар бүр хүүхдийн мөнгө олгоход эх үүсвэр дутагдаж, санхүүжилтийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.7¹-д заасныг баримтлан улсын төсөвт 148.4 тэрбум төгрөгийн өглөг үүсгэж Хүний хөгжил сангийн зарлагыг санхүүжүүлсэн байна.

Хүний хөгжил сангийн 2010-2013 оны орлогыг төлөвлөгөө, гүйцэтгэлээр харуулбал:

/тэрбум.төг/

Орлого	2010		2011		2012		2013	
	Төлөв	Гүйцэт	Төлөв	Гүйцэт	Төлөв	Гүйцэт	Төлөв	Гүйцэт
АМНАТ-ийн 70 хувь	110.0	117.2	136.0	101.7	204.1	216.1	206.6	195.9
ӨСНАТ			117.8	166.8	135.3	114.6	122.6	129.1
Хувьцааны ногдол ашиг	40.9	40.9	44.0	45.0	110.0	110.0	68.3	68.3
Хүүгийн орлого				0.4		0.2		0.2
Ханшийн зөрүүний ашиг				0.2		-		
Мөнгөн хөрөнгийн өөрчлөлт	113.0	89.4	39.7	11.2	23.5	31.5	-	-
Оюу толгой урьдчилгаа зээл	-	68.3	490.9	125.3				
Эрдэнэс МГЛ				336.1	79.9	63.2		
ЗГ-ын бонд					313.1	313.1		
Нийт орлого	263.9	315.8	828.4	786.8	865.9	848.7	397.5	393.5

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

1.7 2013 онд сангийн орлогын бүрдүүлэлтийг 87.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 79.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 7.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

№	Орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө	-	7,3
2	ХЭД төв сангаас хуваарилсан хөрөнгө	2,600.0	-
3	Жижиг зээлийн хүүгийн орлого		450.0
4	Жижиг зээлийн эргэн төлөлт	22,000.0	22,322.3
5	Зээлийн баталгааны сангийн эргэн төлөлт	-	1.4
6	Төрийн сан	-	52.8
7	Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр	62,500.0	47,072.2
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөр	300.0	390.3
9	ХЭД үйл ажиллагааны орлого	-	128.0
10	Мөнгөн гүйлгээний цэвэр дүн	-	9,065.5
	Нийт	87,400.0	79,489.8

¹ "Улсын төсөв болон Хүний хөгжил сангийн төсвийн зарлагыг тогтмол хугацаанд санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг төрийн сангийн нэгдсэн дансны хүрээнд улсын төсөв болон улсын төсвийн ерөнхийлөн захирагчид тухайн жилийн эцэст хаагдсан байхаар мөнгөн хөрөнгийн өглөг үүсгэн бүрдүүлэх"

1.8 Засгийн газрын тогтоолоор 2013 онд 27191 гадаадын иргэнд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн урилга олгож, 15989 гадаадын иргэн ирснээс 3045 иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн байна.

Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 60 дугаар тогтоолоор ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн компаниудыг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Хугацаа	Квот чөлөөлсөн тоо	Ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн тоо	Сар бүр төлөх төлбөр/сая. төг/
1	БНСУ-ын \Бексок\ констракшн компани	2013.02.23	177	177	49.7
2	Жянши уотер энд хайдропауэр ХХК	2013.02.23	360	360	101.0
3	Халла инженеринг энд констракшн	2013.02.23	360	360	101.0
4	Хунан констракшн инженеринг компани	2013.02.23	6	6	1.6
5	Чайна Гео-инженеринг корпораци	2013.02.23	52	52	14.6
6	Чайна жиансу жианда констракшн ХХК	2013.02.23	902	902	253.2
7	Чайна машинуару индустри констракшн	2013.02.23	280	280	78.6
8	Чайна рейлвей ферст групп компани	2013.02.23	408	408	114.5
9	Эрдэнэс таван толгой	2013.09.28	500	500	140.4
Нийт			3045	3045	855.0

1.9 ЗГ-ын 2009 оны 26 дугаар тогтоолд 25 ажилтан тутамд нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах, хэрвээ ажиллуулаагүй бол сар бүр төлбөр төлөх тухай заасан байна. Үүний дагуу ХЭДС-д 300.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 390.0 сая төгрөгийн орлого олсон байна.

1.10 Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 20-иос дээш ажилтантай 2906, 50-иас дээш ажилтантай 1780 нийт 4686 ААН байхад ХЭДС-д 392.0 сая төгрөг төвлөрсөн нь дээрх тогтоолын хэрэгжилт хангалтгүй, сангийн хөрөнгө нэмэгдэх боломж алдагдсаныг харуулж байна.

1.13 ХЭДС-аас олгосон жижиг зээлийн эргэн төлөлтийг 2013 онд 22.0 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 22.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

1.14 2013 онд тус санд нийт 3.5 тэрбум төгрөгийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 501 байгууллага төвлөрүүлэхээс 71 байгууллага 2.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь санд төвлөрөх нийт хөрөнгийн 80.5 хувь байна.

БНҮҮС-ийн орлогын бүрдүүлэлт, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоог сүүлийн 5 жилийн байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

Утга	2009	2010	2011	2012	2013	Нийт дүн /тайлбар/	
Хөрөнгө төвлөрүүлэлт /тэрбум.төг/	Төлөвлөгөө	2.3	1.9	2.5	3.5	3.5	13.7
	Гүйцэтгэл	1.8	3.3	3.3	4.3	2.9	15.6
ХХЗХ-с тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо	629	653	657	656	501	Тайлбар: 88 байгууллага хаяг тодорхойгүй, 156 ААН тодорхой шалтгаангүйгээр тайлан ирүүлээгүй, 89 ААН хасах баланстай тайлан ирүүлсэн.	
Мэдэгдэл хүргүүлсэн байгууллагын тоо	170	197	307	326	413		
Тайлан ирүүлсэн байгууллагын тоо	120	168	174	145	257		
Хөрөнгө төвлөрүүлсэн байгууллагын тоо	31	66	78	43	71		

1.15 МШХХТГ-аас 413 аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлж, санхүүгийн тайлангаа 257 аж ахуйн нэгж ирүүлснээс 71 нь хөрөнгө төвлөрүүлж, 89 нь алдагдалтай тайлан ирүүлж, 97 байгууллагаас 845.0 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна. Үлдсэн 156 байгууллага тайлан ирүүлээгүй, 88 байгууллага хаяг тодорхойгүй байгаа нь хөрөнгө төвлөрүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

1.16 МШХХТГ БНҮҮС-д төвлөрөх хөрөнгийг бүрэн бүрдүүлээгүй нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1², 22.2³ дахь заалт, “БНҮҮС-д хөрөнгө төвлөрүүлэх журам”-ын 3⁴ дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд мөн журмын 4⁵ дүгээр зүйлд заасан үүргийг тус тус биелүүлээгүй байна.

² Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ: энэ хуулийн 7.2-т заасан эх үүсвэр; харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгө.

³ төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь тухайн этгээдийн албан татвар ногдуулах орлогын 2 хувьтай тэнцүү байна.”

⁴Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санд хөрөнгө төвлөрүүлэх, тайланг журмын маягтын дагуу гаргуулан, татварын албанд тайлагнасан санхүүгийн тайлангийн хамт тайлант улирлын дараа улирлын эхний сарын 25-ны дотор авах, ирүүлэхийг шаардах.

⁵ МШХХТГ-аас баталсан санд хөрөнгө төвлөрүүлэх тайлангийн маягтыг мөрдөх, Тухайн улиралд санд төвлөрүүлэхээр МШХХТГ-аас баталгаажуулсан хөрөнгийг дараа улирлын дундах сарын 25-ны дотор Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлэх,

Бүлэг 2. Сангуудын зарцуулалтын талаар

Нийгмийн даатгалын зарим сангийн хөрөнгийн зарлага батлагдсан төлөвлөгөөнөөс давж гарсан байна

2.1 Нийгмийн даатгалын 5 сангийн зарлагын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл:

Нийгмийн даатгалын сан	2012	2013 оны төлөвлөгөө		Гүйцэтгэл		Давсан	
		Зарлага	Эзлэх хувь	Зарлага	Эзлэх хувь	Дүн	Хувь
Тэтгэврийн	722.5	829.3	77.7	826.4	78.10	2.9	0.31
Тэтгэмжийн	42.6	57.5	5.4	58.6	5.55	-1.1	-2.09
ҮОМШӨ-ний	28.5	34.3	3.2	31.4	2.97	2.9	8.16
Ажилгүйдлийн	7.7	15.3	1.4	16.1	1.52	-0.8	-5.23
Эрүүл мэндийн	117.4	131.4	12.3	125.5	11.86	5.9	4.41
Нийт	918.7	1,067.8	100.0	1,058.0	100.0	9.8	0.86

Тэтгэмжийн даатгалын сан:

2.2 Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага даатгуулагчийн дундаж цалингийн өсөлт, төрөлт нэмэгдсэнээс шалтгаалан 1.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2013 онд жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 38.5 мянган хүнд олгохоор төлөвлөснөөс 45.7 мянган хүнд тэтгэмж олгосон байна. Энэ нь төрөх насны эмэгтэйчүүдийн тоо урьд оноос 7.2 мянган хүнээр өссөнтэй холбоотой байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас 162.5 мянган даатгуулагчдад 58.6 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмжийг олгожээ. Хүснэгтээр үзүүлбэл:

Тэтгэмжийн төрөл	Хүний тоо				2013 он			
	2012	2013	Өсөлт, бууралт	хувь	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Өсөлт, бууралт	хувь
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	98.9	104.4	5.5	5.6	10.6	10.2	0.4	3.7
Жирэмсний болон амаржсаны	38.5	45.7	7.2	18.7	42.3	44.7	-2.4	5.7
Оршуулгын тэтгэмж	12.9	12.4	-0.5	3.9	4.5	3.7	0.8	17.7
Нийт	150.3	162.5	12.2	8.1	57.4	58.6	-1.2	2.1

Ажилгүйдлийн даатгалын сан:

2.3 Ажилгүйдлийн тэтгэмжийн өсөлт нь 2013 онд улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 35776 байснаас 42772 болж 6996 хүнээр өссөнтэй холбоотой байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлэлт	Хүний тоо / Өсөлт+, бууралт-/				2013 он		Өсөлт, бууралт	
	2012	2013	Дүн	Хувь	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Дүн	хувь
Ажилгүйдлийн тэтгэмж	10.5	15.9	5.4	51.4	13,383.5	14,905.4	1,521.9	11.4
Сургалтын төлбөр	0.05	0.01	-0.04	8	43.8	0.05	-43.75	99.8
Нийт дүн	10.55	15.91	5.36	50.8	13,427.3	14,905.45	1,478.15	11.0

2.4 2013 онд ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авагч 11.4 мянган хүнээр төлөвлөснөөс 15.9 мянган хүн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна. Уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа зогсоож татан буулгасантай холбоотойгоор ажилгүйдлийн тэтгэмж авах хүний тоо 39.5 хувиар өссөн, нийгмийн даатгалын сангийн төсөв УИХ-д өргөн барьж батлагдсанаас хойш НХХЯ-ны (хуучнаар) бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөн Хөдөлмөр халамж үйлчилгээний алба татан буугдаж сургалтын зардал олгогдоогүйгээс сургалтын төлбөр хэмнэгдсэн байна.

ЗГ-ын зарим тусгай сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байна

Эрүүл мэндийг дэмжих сан

2.5 2013 оны төсвийн тухай хуулиар ЭМДС-ийн 2013 оны үйл ажиллагаанд зориулж 3,989.4 сая төгрөг баталсан байна. Үүний дагуу ЭМС-ын 2013 оны 162 тоот тушаалаар сангийн 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, зардлын хуваарилалтыг баталсан байна.

2.6 Сангийн хөрөнгөөр 2013 онд нийт 133 төсөл арга хэмжээг 2,469.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Эдгээрээс 6 төсөл хөтөлбөрийн 230.4 сая төгрөгийг ажлын гүйцэтгэл бүрэн гараагүй байхад гэрээний заалтыг зөрчин урьдчилж олгосон байна.

2.7 ЭМС-ын 2013 оны 423 тоот тушаалаар сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, 200.0 сая төгрөгийн өртөг бүхий 18 арга хэмжээг хасаж, өсвөр залуу үеийг архи, тамхины хамааралд өртүүлэхгүй байх урьдчилан сэргийлэх, амьдралын зөв хэвшилд сургах зорилгоор “Залуус-21” алкохолгүй диско төвийг байгуулах, тохижуулахад зарцуулжээ. Энэ хүрээнд нийт 124.5 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авч үндсэн хөрөнгө бэлтгэсэн байх бөгөөд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, сангийн хөрөнгөөр бэлтгэгдсэн үндсэн хөрөнгийг хууль журмын дагуу үнэлж, данс бүртгэлд тусгаагүй, төрийн бус байгууллагын мэдэлд орхисон байна.

2.8 Энэ төслийн хүрээнд өсвөр залуу үеийг архи, тамхины хамааралд өртүүлэхгүй байх урьдчилан сэргийлэх, амьдралын зөв хэвшилд сургах зорилготой байгуулагдсан “Залуус-21” алкохолгүй диско төв нь одоогоор үйл ажиллагаагаа зогсоосон байна.

2.9 ЭМДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг тус сангийн Удирдах зөвлөл болон ЭМС шууд сонгож, шийдвэрлэж байгаа нь ЗГ-ын 2007 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ын 1.4⁶ дэх заалтыг зөрчиж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

2.10 ХЭДС 2013 онд гүйцэтгэлээр 79.4 тэрбум төгрөг төвлөрүүлж дараах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

№	Зарцуулалт	/Тэрбум.төг/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр	28.7	25.4
2	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих жижиг зээл	30.0	30.0
3	Сум хөгжүүлэх санд хуваарилсан хөрөнгө	24.0	24.0
Нийт		82.7	79.4

2.11 ХЭҮЗ-ийн 2012 оны 4 дүгээр тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 9 төсөл, хөтөлбөрт 2013 онд 25.4 тэрбум төгрөгийг ХЭДС-аас зарцуулсан байна.

2.12 Хөтөлбөрт заасан арга хэмжээ болох зөвлөгөө мэдээлэл өгөх, төрөл бүрийн сургалт зохион байгуулах мэргэшсэн байгууллагууд цөөн байсан учраас хөрөнгийг зарцуулаагүй үлдэгдэлтэй гарчээ.

⁶ Сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгоно

Төсөл, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийг тус бүрээр хүснэгтээр үзүүлбэл:

№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	(сая.төг)
			Гүйцэтгэл
1	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	498.7	413.1
2	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөр	4,400.0	3,500.0
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2,300.0	2,100.0
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	13,976.1	10,858.5
5	Ажил олгогчийг дэмжих хөтөлбөр	1,720.0	666.6
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	200.0	101.7
7	40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	1,020.0	643.5
8	Эзэнтэй монгол хөтөлбөр	4,600.0	4,166.7
9	Хөдөлмөрийн салбарын байгууллага, ажилтны чадавх сайжруулах, бэхжүүлэх	3,000.0	3,000.0
Нийт		28,714.8	25,450.1

2.13 Аймаг, нийслэлийн дүүргүүдэд хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хийсэн аудитаар сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд нийт 162.7 сая төлбөрийн акт, 421.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

2.14 Аймаг, орон нутгийн иргэдэд үүрэн холбооны болон интернетийн үйлчилгээ хүргэх, шуудангийн үйлчилгээний хүргэлт, давтамжийг нэмэгдүүлэх телевизийн олон суваг хүргэх хамрах хүрээг нэмэгдүүлэх, тоон технологид суурилсан радио өргөн нэвтрүүлгийн ажилд 2013 онд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс 21 аймгийн давхардсан тоогоор алслагдсан 241 сум, 3 багт нийт 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

2.15 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд ашиглалтад орсон үндсэн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн дансанд бүртгэсэн байна. *Тухайлбал: 2013 онд “Жи-Мобайл” ХХК, “Мобиком” ХХК-ийн өмчид нийт 699.4 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж бүртгэсэн.*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан *“Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т *“төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Архидан согтуурахтай тэмцэх сан

2.16 Архидан согтуурахтай тэмцэх сангийн санхүүжилтээр 2013 онд хийх арга хэмжээнд 11 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж хамтран ажиллах 674.5 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон, ажлын гүйцэтгэл гэрээнд заасан хугацааны дагуу хэрэгжсэн байна.

2.17 ХЗЯ-аас ШШГЕГ-тай байгуулсан “Архины хамааралтай этгээдийн зан үйлд нөлөөлөх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээ”-ний дагуу бэлэн мөнгөөр 82.9 сая төгрөгийг тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авсан нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13².6, дээрх гэрээний 3.4 дэх заалттай нийцэхгүй байна.

2.18 ХЗЯ-ны ТНБД-ын 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Замын цагдаагийн газартай байгуулсан “Архидан согтуурахтай тэмцэх ажлын хүрээнд сургалт, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 52.6 сая төгрөгөөр багаж хэрэгсэл шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөж ажиллаагүй байна.

Бүлэг 3. Хяналт шалгалтын талаар

Сангийн хөрөнгийг зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт үр дүн хангалтгүй байна

Нийгмийн даатгалын сан

3.1 НДЕГ 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хуваарийнхаа дагуу нийт 14 аймаг, 2 дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, 58 сумыг хамруулан нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд хяналт шалгалтыг хийжээ.

3.2 Энэ ажлын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 66 аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 339.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 249.5 сая төгрөг буюу 73.4 хувийг барагдуулсан, нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 87 ажил олгогч, барилгын угсралт, засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 78 ажил олгогч байгууллагад шалгалт хийж, нийт 965.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 959.9 сая төгрөг буюу 99.5 хувийг барагдуулжээ.

3.3 Салбарын хэмжээнд дотоод хяналт, шалгалт хийгдэж байгаа боловч зөрчил дутагдал давтан гарсаар байгаа нь сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Хүний хөгжил сан

3.4 Сангийн яамны Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс явуулсан шалгалтын дүнд иргэнд олгосон бэлэн мөнгөний санхүүжилтийг хуваарилах явцад 2000 орчим иргэнд давхар санхүүжилт олгосон зөрчил илэрсэн байна.

Хүний хөгжил сангийн тухай хууль 2009 онд батлагдаж, хэрэгжсэн боловч дотоод хяналтыг тогтмол хийдэггүйгээс зөрчил дутагдал гарсаар байна.

Эрүүл мэндийг дэмжих сан

3.5 ЗГ-ын 2012 оны 123 дугаар тогтоолоор баталсан ЭМДС-ийн дүрмийн 3 дугаар заалтын 3.1-д⁷ заасны дагуу ЭМД сангийн үйл ажиллагааг ЭМЯ-ны холбогдох нэгж хариуцан ажиллаж байна.

3.6 ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас ЭМДС-ийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд дотоод хяналт, шалгалт хийгээгүй бөгөөд ЭМДС-ийн зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар заалтын 3.1.2 дахь⁸ заалтын дагуу хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

3.7 Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл болон орон нутгийн салбар зөвлөл нь дүрэмд заагдсан эрх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.8 Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт аудитаас илэрсэн зөрчил болон сангийн төлөвлөсөн хөрөнгө бүрэн зарцуулагдаагүй байдлаас харахад ХЭҮЗ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөтөлбөр төслийн хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй, ХЭДС-ийн орлого зарлагын байдалд хяналт тавих үүргээ биелүүлээгүй байна.

⁷ Сангийн удирдлага нь орон тооны бус Сангийн удирдах зөвлөл байх бөгөөд сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрх олгосон холбогдох нэгж хариуцан гүйцэтгэнэ

⁸ Сангийн хөрөнгийн орлого, зарлагын байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх

3.9 Хөдөлмөрийн яам болон орон нутгийн салбарын үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудит хийгдэж байгаа ч төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт шинжилгээ хангалтгүй байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

3.10 Сангийн орон тооны бус Хяналтын зөвлөл нь Мэдээлэл технологийн салбарын төрийн болон хувийн салбарын төлөөллөөс бүрдсэн 9 гишүүнийг 2 жилийн хугацаанд ажиллуулахаар МТШХХГ-ын дарга томилж, чөлөөлдөг байна.

3.11 БНҮҮС-ийн Үйл ажиллагааны дүрэмд заасны дагуу Хяналтын зөвлөл жилд нэгээс доошгүй хуралддаг бөгөөд энэхүү хурлаараа “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.5.1-5.5.3⁹-т заасан үүргийг биелүүлэх талаар хангалтгүй ажиллажээ.

Архидан согтуурахтай тэмцэх сан

3.12 ХЗЯ-аас АСТС-ийн дүрмийн 3 дугаар заалтын 3.1.3-т заасан “Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавих, тайланг хэлэлцэх” гэсэн үүргийг хэрэгжүүлээгүй бөгөөд АСТС-ийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.

⁹1. Сангийн үйл ажиллагаа хууль тогтоомж, дүрмийн дагуу явагдсан эсэх,

2. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт болон зарцуулалттай танилцаж, санал зөвлөмж өгөх,

3. Тухайн жилд төлөвлөж баталсан арга хэмжээнүүдийн биелэлтийн үр дүнг нийтэд мэдээлэхэд оролцох

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аудитад хамрагдсан ЗГ-ын 6 тусгай сангийн НДС, ХХС, ХЭДС нь бие даасан хуулиар, БНҮҮС, ЭМДС, АСТС нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон ЗГ-ын тогтоолоор батлагдсан дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.
2. НДС, ХХС, ХЭДС, БНҮҮС-ийн орлогын эх үүсвэрийг хууль, журам дүрэмд тодорхой заасан, жил бүр орлогын төлөвлөгөө нь батлагддаг бол АСТС-ийн орлогын эх үүсвэрийг хуульд тусгайлан заагаагүй учир төсвийн шууд санхүүжилт хэлбэртэй байна. ЭМДС-ийн орлогын эх үүсвэрийг ЗГ-ын тогтоолоор баталсан дүрэмд тодорхой заасан боловч тус сангийн орлогыг төлөвлөхгүй төсвийн шууд санхүүжилт хэлбэрээр зарлагыг нь санхүүжүүлж байна.
3. Дээрх сангуудын хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хөрөнгө бэлтгэгдэж, төсөл хэрэгжүүлэгч төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн данс бүртгэлд бүртгэгдсэн байна. Энэ хүрээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай, улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаагүй арга хэмжээ хэрэгжиж, урсгал төсвөөс санхүүжсэн байна.
4. Тусгай сангийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨБАҮХАТ хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэхгүй байгаа зөрчил нийтлэг байна.
5. Тусгай сангийн бодлого, үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад салбарын дотоод шалгалт хийгдэж байгаа ч тусгай сангуудын хяналт, хариуцлагын тогтолцоо сул, сангийн зөвлөлүүд үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.
6. Сангуудын хамтын удирдлагын тогтолцоо нэг мөр, оновчтой болгох, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг бүртгэх, төлөвлөх, гүйцэтгэлийг хянах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна.
7. Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 14.1 хувь нь зохих төлбөрөө төлж сангийн орлого бүрдүүлэхэд оролцож байна. Энэ нь тусгай зөвшөөрөл олголт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүргийн хэрэгжилтийг тусгайлан хянаж, шаардлагатай арга хэмжээ авах цаг болсныг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын ерөнхий сайд Н. Алтанхуяг-д:

1. ЗГ-ын тусгай сангийн орлого зарлагыг төлөвлөхдөө урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардлыг ангилж, Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэх;
2. ЗГ-ын тусгай сангийн орлого, зарлагын төлөвлөлт, сангийн төсвийн төсөл, төсөөллийг боловсруулахад баримтлах нэгдсэн аргачлал, арга зүйтэй болох;
3. ЭМДС, АСТС-г нэгтгэж, удирдах зөвлөлд эрүүл мэндийн, хууль хяналтын, нийгмийн хамгааллын гэх мэт ЗГ-ын холбогдох байгууллагуудын төлөөллийг оруулах, орлогын төлөвлөлтийг сайжруулах, зардлыг оновчтой болгох, үр дүнг дээшлүүлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах;
4. Засгийн газрын тусгай сангуудын хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн бүртгэл өмчлөлийн асуудлыг шалган тодруулж, хууль журамд нийцүүлэх арга хэмжээ авах;
5. БНҮҮС-ийн тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрээс хуульд заасан төлбөрийг төлдөг болгох, эсвэл тусгай зөвшөөрөл эзэмшлийг цуцлах асуудлыг судалж шийдвэрлэх.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсүгэй.
4. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хамжээ авч, үр дүнг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн сайд, Хууль зүйн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга нарт зөвлөсүгэй.
5. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД